



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ ХОРОО

Нэгдсэн үндэстний гудамж 20, Сүхбаатар дүүрэг
6-р хороо, Улаанбаатар 14200-0063

Утас: 70071113, 70071117

Цахим шуудан: secretariat@gender.gov.mn

Цахим хуудас: www.gender.gov.mn

ЯАМДЫН ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА, ЖЕНДЭРИЙН
САЛБАР ЗӨВЛӨЛИЙН ДАРГА
НАРТ

2023.12.26 № 219
танай _____-ны № _____-т

Мэдээлэл ирүүлэх тухай

Улсын их хурлын Нийгмийн бодлогын болон Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хуралдаанаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг хэлэлцсэн.

Байнгын хорооны хуралдааны үеэр гишүүдээс гаргасан саналыг үндэслэн ажлын байрны бэлгийн дарамтын эрхзүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, хөдөөгийн охид эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн байдал, малчин залуу гэр бүлд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлж, холбогдох мэдээллийг ирүүлэх талаар Засгийн газарт хандсан болно.

Энэ хүрээнд хавсралтаар хүргүүлж буй маягтын дагуу холбогдох мэдээллийг салбарын чиг үүргийн хүрээнд үндэсний хэмжээнд нэгтгэн дүгнэж, тайланг 2024 оны 02 дугаар сарын 01-ний дотор ирүүлнэ үү.

Монгол Улсын Их хурлын Нийгмийн бодлогын байнгын хорооны 2023 оны УИХ-09/10324 тоот албан бичгийг хавсаргав.


Хавсралт: 4 хуудастай.

Хүндэтгэсэн,

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
БӨГӨӨД АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА



Т.ЭНХБАЯР



МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН
БАЙНГЫН ХОРОО

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг
Жанжин Д. Сүхбаатарын талбай 1 Төрийн ордон,
Утас: 26-70-16, Факс: 32-70-16
E-mail: stategreatkhural@parliament.mn
http://www.parliament.mn

57
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД,
ЖЕНДЭРИЙН ҮНДЭСНИЙ
ХОРООНЫ ДАРГА
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ
ТАНАА

2023.12.14 № 412-09/10324
танай _____-ны № _____-т

Мэдээлэл ирүүлэх тухай

Монгол Улсын Их Хурлын Нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны 2023 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хамтарсан хуралдаанаар Жендэрийн эрх тэгш байдлыг хангах үйл ажиллагааны хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг хэлэлцсэн. Байнгын хорооны хуралдааны үеэр гишүүдээс гаргасан саналыг үндэслэн ажлын байрны бэлгийн дарамтын эрх зүйн зохицуулалтад дүн шинжилгээ хийж, хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн нийгэм, эдийн засгийн байдал, малчин залуу гэр бүлд чиглэсэн бодлого, үйл ажиллагааны хэрэгжилтийг үнэлэн холбогдох мэдээллийг 2024 оны 1 дүгээр улиралд багтаан Нийгмийн бодлогын байнгын хороонд ирүүлнэ үү.

Хүндэтгэсэн,

НИЙГМИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА



П.АНУЖИН

2023001477

ЖЕНДЭРИЙН ЭРХ ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ХЭРЭГЖИЛТ,
 ҮР ДҮНГИЙН ТАЛААРХ ЗАСГИЙН ГАЗРЫН ТАЙЛАН ХЭЛЭЛЦҮҮЛСЭНТЭЙ ХОЛБОГДУУЛАН
 УЛСЫН ИХ ХУРЛЫН НИЙГМИЙН БОДЛОГЫН БОЛОН ХУУЛЬ ЗҮЙН БАЙНГИЙН ХОРООНД
 ХҮРГҮҮЛЭХ МЭДЭЭЛЭЛ

Нэг. Засгийн газрын 2021 оны 42 дугаар тогтоолоор батлагдсан "Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх 10 (арван) их наядын цогц төлөвлөгөө"-нд тусгагдсан төсөл арга хэмжээ, үр шим хүртэгчийн судалгаа

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ	Хариуцах яам	Тайлагнах үзүүлэлт
2.1.Ажлын байрыг дэмжих жилийн 3 хувийн хүүтэй, 3 жилийн хугацаатай 3.0 их наяд төгрөг хүртэлх зээлийг Зээлийн батлан даалтын сангийн тогтолцоог ашиглан, банкуудын чөлөөт эх үүсвэрээр олгох	СЯ, УУХҮЯ, ХХААХҮЯ	- Зээлдэгч, хүйсээр, авсан зээлийн дүн аймаг, нийслэлээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.2.Иргэдийг орон сууцжуулах арга хэмжээг төр, хувийн хэвшлийн зохистой түншлэлээр хэрэгжүүлж, төрөөс газар, дэд бүтэц, ипотекийн хөнгөлөлттэй зээлийн дэмжлэг үзүүлэх	БХБЯ	- Зээлдэгч, хүйсээр, авсан зээлийн дүн аймаг, нийслэлээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.5.Хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөнгөлөлттэй зээлийг Хөгжлийн банк, арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан санхүүжүүлэх	ХХААХҮЯ, ХНХЯ	- Зээлдэгч, хүйсээр, авсан зээлийн дүн аймаг, нийслэлээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
-		
2.52. Аялал жуулчлалын салбарт үйл ажиллагаа эрхлэгчдийг дэмжих хөнгөлөлттэй зээлийг арилжааны банкуудын эх үүсвэрт тулгуурлан санхүүжүүлэх	БОАЖЯ	- Зээлдэгч, хүйсээр, авсан зээлийн дүн аймаг, нийслэлээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.6.Залуучуудын хөгжил, хөдөлмөр эрхлэлтийг дэмжих зорилгоор ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хувь хүний хөгжлийн цогц сургалтын хөтөлбөр боловсруулан, залуучуудыг хамруулж хөдөлмөрт бэлтгэх, ажлын байраар хангахад дэмжлэг үзүүлэх	ХНХЯ, БШУЯ, БХЯ	- Хөтөлбөрт хамрагдсан залуучууд хүйсээр, аймаг, нийслэлээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.7."Өрхийн тариалан" хөдөлгөөн өрнүүлж, аж ахуйн нэгжүүдэд хүнсний ногооны үрийн дэмжлэг үзүүлэх	ХХААХҮЯ	- Дэмжлэгийн дүн, аймаг, нийслэлээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.8. Малжуулах хөтөлбөрт хамрагдах хүсэлтэй малгүй болон цөөн малтай иргэн, гэрээт малчин өрхийг малжуулахад санхүүгийн зохих дэмжлэг үзүүлэх	ХНХЯ	- Санхүүгийн дэмжлэгийн дүн, аймаг, нийслэлээр, дэмжлэг авсан иргэд хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.9. Өвөлжилт, хаваржилтыг хүндрэлгүй даван туулахад зориулж малчин өрхөд санхүүгийн дэмжлэг үзүүлэх	ХХААХҮЯ	- Санхүүгийн дэмжлэгийн дүн, аймаг, нийслэлээр, дэмжлэг авсан иргэд хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.10. Хувиараа хөдөлмөр эрхлэгч, бичил үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдэд санхүүгийн дэмжлэг олгох	ХНХЯ	- Санхүүгийн дэмжлэгийн дүн, аймаг, нийслэлээр, дэмжлэг авсан иргэд, хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.19. Дотоодын үйлдвэрлэл, ногоон худалдан авалтыг төрийн худалдан авалтаар дэмжих	ХХААХҮЯ, ТХААГ	- Дэмжлэг арга хэмжээ, санхүүжилтийн дүн, аймаг, нийслэлээр, үр шим хүртэгч, иргэд хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр

2.24.Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг хөдөлмөрт бэлтгэж ажлын байраар хангах, аж ахуй эрхлэх үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх болон ажлын байраар хангасан аж ахуйн нэгж, байгууллагыг дэмжиж, урамшуулах,	ХНХЯ	- Аж ахуйн нэгж байгууллагыг дэмжих урамшуулах арга хэмжээ, үр шим хүртсэн байгууллагаар, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.23. Хувиараа хөдөлмөр эрхлэх сонирхолтой ажилгүй, гэртээ хүүхэд асарч буй иргэн, хөдөлмөрийн насны халамж хүртэгчид өрхийн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхтэй холбоотой борлуулалтын болон ажлын байрны түрээсийн дэмжлэг үзүүлэх	ХНХЯ	- Дэмжлэг санхүүжилтийн хэмжээ, аймаг, нийслэлээр, үр шим хүртэгч хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
2.30.Эрчим хүчний салбарын нарийн мэргэжлийн ажилтны хүний нөөцийг бүрдүүлэх	ЭХЯ	- Шинээр бэлтгэгдсэн нарийн мэргэжлийн хүний нөөц, хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр.

Хоёр. Монгол Улсын Их Хурлын 2021 оны 106 дугаар тогтоолоор батлагдсан "Шинэ сэргэлтийн бодлого"-д тусгагдсан төсөл арга хэмжээ, үр шим хүртэгчийн судалгаа

Төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээ	Хариуцах яам	Тайлагнах үзүүлэлт
Аж үйлдвэржилтийн сэргэлт 3.4.1.Мал аж ахуйн гаралтай түүхий эдийн анхан шатны боловсруулалтын түвшнийг сайжруулж, нэмүү өртөг шингэсэн бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг нэмэгдүүлнэ.	ХХААХҮЯ ХНХЯ	- Бодит орлого нэмэгдсэн малчдын тоо, аймгаар, хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
Арьс ширний боловсруулалтын түвшнийг 60 хувьд хүргэх замаар малын гаралтай бүтээгдэхүүний үнийг тогтворжуулж, малчдын бодит орлого нэмэгдсэн байна.		
Экспортыг 232.7 сая ам.доллаар нэмэгдүүлж, 32.7 тэрбум төгрөгийг улсын төсөвт татан төвлөрүүлнэ. Жилдээ 4.5 сая ширхэг арьс, шир боловсруулах 5 үйлдвэр, дагалдах 3 үйлдвэр байгуулагдаж, нийтдээ 2.4 мянган ажлын байрыг бий болгосон байна.	ХХААХҮЯ ХНХЯ	- Холбогдох салбаруудад шинээр бий болгосон ажлын байрны тоо, шинээр ажилд орсон иргэд, аймгаар хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
3.4.4.Сэлэнгэ, Хөвсгөл, Дархан-Уул аймаг, нийслэлд төрөл бүрийн шахмал хавтан, модон бүтээгдэхүүний үйлдвэрлэлийг хөгжүүлнэ.	ХХААХҮЯ, БОАЖЯ	- Ажлын байраар хангагдсан орон нутгийн иргэд, аймгаар, хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
Жилдээ 50000 куб метр модыг эдийн засгийн эргэлтэд оруулж, шахмал модлог хавтангийн дотоодын зах зээлийн 70 хувийг хангаж, экспортод үйлдвэрлэлийн 37 хүртэлх хувийг нийлүүлсэн байна. 2500 ажлын байр бий болсон байна.		
4.2.5.Орон нутагт шилжсэн иргэнийг ажилд авсан жижиг, дунд үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгох хууль, эрх зүйн орчныг бүрдүүлэх	ХЗДХЯ	- Орон нутагт шилжсэн иргэнийг ажилд авсан жижиг, дунд үйлдвэрт хөнгөлөлттэй зээл олгох хууль, эрх зүйн орчин бүрдсэн эсэх
4.2.7. Орон нутагт шилжсэн болон суурьшиж байгаа иргэн, өрх, хөдөлмөр эрхлэгчдийг хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу инженерийн дэд бүтэцээр хангагдсан орон сууцаар хангахад дэмжлэг үзүүлэх	БХБЯ ХНХЯ ХХААХҮЯ	- Дэмжлэг авсан иргэд, аймгаар, хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
4.2.6.Орон нутагт үйлдвэрлэл, үйлчилгээ, хүн амын	БХБЯ	- Орон нутагт шинээр бий

төвлөрлийг бий болгохын тулд инженерийн дэд бүтцийг барьж байгуулах		болсон, ажлын байр, аймгаар, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
4.2.8. Орон нутагт бизнесийн орчныг дэмжих, хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэдийг малжуулах болон бусад хөдөө аж ахуйн чиглэлийн жижиг бизнесийг төрөөс бодлогоор дэмжих	ХНХЯ ХХААХҮЯ	- Хотоос хөдөө рүү шилжин суурьшиж байгаа иргэдийг малжуулах болон бусад хөдөө аж ахуйн чиглэлийн жижиг бизнес үзүүлсэн дэмжлэг, сая төгрөгөөр, үр шим хүртэгч иргэд, аймгаар, хүйсээр, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
4.2.10. Зарим их, дээд сургуулийг мэргэжлийн чиглэл, салбараар нь төрөлжүүлж, дагуул хотууд болон орон нутагт хотхон байгуулан шилжүүлэх замаар хотын төвлөрлийг сааруулах	БШУЯ	- Дагуул хотууд болон орон нутагт шилжүүлсэн их, дээд сургууль, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
4.3.2. Сумдын инженерийн дэд бүтцийн хангамжийн ашиглалт, үйлчилгээг нэгдсэн байдлаар зохион байгуулж, хэрэглэгчдэд иж бүрэн, чирэгдэлгүй үйлчилгээг үзүүлэх	БХБЯ	- Нийтийн аж ахуйн иж бүрэн үйлчилгээгээр хангагдсан аймгийн тоо, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр
4.4.1.Тэжээлийн ургамал, эмийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, загас үржүүлэх үйл ажиллагаа эрхлэгчдийг бодлогоор дэмжих, 3500 га-аар жимсний талбайг нэмэгдүүлж, 450 байршилд агро ойн аж ахуйг хөгжүүлж, 120 га талбайд тариалангийн талбайн хамгаалалтын зурвас байгуулсан байна.	ХХААХҮЯ, ХНХЯ	- Тэжээлийн ургамал, эмийн ургамал тариалах, хүлэмжийн аж ахуй эрхлэх, загас үржүүлэх зэрэг байгаль орчинд ээлтэй бизнес эрхэлж буй иргэдийн тоо, 2021, 2022, 2023 оны үзүүлэлтээр.

Гурав. ЖҮХ-ны 2022 оны 2 дугаар тогтоолоор батлагдсан "Жендэрийн эрх байдлыг хангах салбар дундын стратеги төлөвлөгөө"-д тусгагдсан төсөл арга хэмжээний хэрэгжилт тайлагнах хүснэгт

№	Зорилго, зорилт, үйл ажиллагаа	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин			Зорилтот түвшин	Хариуцаж байгууллага	Хэрэгжилт
			2021/2022	2026	2031			
0	1	2	4	5	6	7	8	
1.1.2	Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний болон өвчлөлөөс урьдчилан сэргийлэх зардал, эрүүл мэндийн даатгалын сангийн зарцуулалтад жендэрийн шинжилгээ хийж, шийдвэр гаргалтад ашиглана.	Эрүүл мэндийн нийт төсөвт нийгмийн эрүүл мэндэд зарцуулсан төсөв	4	10	50	ЭМЯ		
1.1.3	Нийгмийн эрүүл мэндийн болон эмнэлгийн тусламж үйлчилгээ, дэд бүтцийг жендэрийн мэдрэмжтэй хөгжүүлнэ.	Жендэрийн мэдрэмжтэй үйлчилгээ, дэд бүтэц бүрдүүлсэн эрүүл мэндийн байгууллага	0	20	40	ЭМЯ		
1.1.12	Эмэгтэйчүүдийн эсэн мэнд амаржихуй, жирэмсний болон дараах үеийн эрүүл мэндийн үйлчилгээг жендэрийн мэдрэмжтэй төлөвлөн	Судалгаа, бодлого төлөвлөл-тий хэрэгжилт	40	70	100	ЭМЯ		

3

хэрэгжүүлнэ.		Жендэрийн шинжилгээ, бодлого төлөвлөлт хийгдсэн эсэх, хэрэгжилт	Үгүй	Тийм	-	ХНХЯ	
1.1.13	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн, хүүхэд, тэднийг асран харгалзагчдын нийгмийн амьдралд оролцоход тулгарч байгаа саад бэрхшээлд жендэрийн шинжилгээ хийж, салбар дундын төлөвлөлт хийж хэрэгжүүлнэ.		-	-	50		
1.2.7	Дотуур байранд амьдардаг бага ангийн хүүхдийг дэмжих туслах багш ажиллуулах эрх зүйн орчин бүрдүүлж, дотуур байранд амьдрахад нь дэмжлэг үзүүлэх орчин, үйлчилгээг бий болгоно.	Хуулийн өөрчлөлт хийгдсэн эсэх, Орчин, үйлчилгээ бүрдсэн дотуур байр		Тийм	30	100	БШУЯ
1.2.8	Малчдын хүүхдэд СӨБ, бага боловсрол олгох орчныг жендэрийн хувьд ээлтэй болгох Увс аймгийн Бөхмөрөн сумын сайн туршлагыг түгээн дэлгэрүүлнэ.	Сайн туршлага нэвтрүүлсэн сум	Туршлага дэлгэрүүлэх төлөвлөгөө	10	20	БШУЯ	
1.2.11	Цэцэрлэгийн болон бага ангийн багшийн үндсэн цалин хөлс, урамшууллыг нэмэгдүүлэх тусгай арга хэмжээ авч хэрэгжүүлнэ.	Тусгай арга хэмжээ авсан, хэрэгжилт-тэд үнэлгээ хийсэн эсэх	Үгүй	Тийм	Тийм	БШУЯ	
1.2.12	Сургууль завсардсан окид, хөвгүүд, өрх толгойлсон залуу эмэгтэйчүүдийг дахин суралцуулах, мэргэжил олгоход шаардлагатай дэмжлэг үзүүлнэ.	Суралцагчид, нас, хүйсээр	Тодорхойлох шаардлагатай	Суурийг 35 хувиар үлэх	Суурийг 70 нэмэгдүү-лэх	БШУЯ	
1.2.14	Орон нутгийн МСҮТ, политехник коллежийн "малчин" мэргэжил эзэмшүүлэх хөтөлбөрт жендэрийн үнэлгээ хийж, жендэрийн үзэл баримтлал нэвтрүүлж боловсронгуй болгоно.	Жендэрийн мэдрэмжтэй сургалтын хөтөлбөртэй эсэх	Үгүй	Тийм	Тийм	ХХААХҮЯ	
1.4	Зорилт 1.4. Хөдөөгийн окид, эмэгтэйчүүдийн амьдралын орчин, суурь нөхцөлийг сайжруулна.	Хүн амын нутагшилт, суурьшлын ерөнхий төлөвлөлтийн хэрэгжилт: Хөдөө ажиллаж, амьдарч буй иргэд	30.5	40	60	ЭЗХЯ	
1.4.1	Аймгийн төвөөс алслагдмал амьдарч буй жирэмсэн эмэгтэйчүүдийн хяналтын явуулын	Эхийн амрах байртай болгож, сумандаа	0	30	70	ЭМЯ	

4

	тусламж, үйлчилгээг хөгжүүлж, эхийн амрах байртай болгож, сумандаа амаржих нөхцөлийг бүрдүүлнэ.	амаржих нөхцөлийг бүрдүүлсэн сум					
1.4.2	Малчин эмэгтэй, эрэгтэйчүүдэд бэлгийн, нөхөн үржихүйн эрүүл мэнд, гэр бүл төлөвлөлт, хүчирхийлэлгүй харилцааны талаарх мэдээллийг тогтмол хүргэнэ.	Мэдээллийг тогтмол хүргэдэг сум, баг	0	50	100	ЭМЯ	
1.4.3	Малчдын хөдөлмөрийг хөнгөвчлөх арга технологи нэвтрүүлэх, хос аж ахуй эрхлэх, хоршоо болон сүлжээнд нэгдэн ажиллах чиглэлээр малчин өрхийн эмэгтэйчүүдэд сургалт, зөвлөгөө өгөх инкубатор хөгжүүлнэ.	Инкубатор	-	10	21	ХХААХҮЯ	
1.4.4	Залуу малчдыг чадавхжуулах сургалтын хөтөлбөрийг жендэрийн мэдрэмжтэй боловсруулан нэвтрүүлнэ.	Жендэрийн мэдрэмжтэй хөтөлбөр	0	1	-	ХХААХҮЯ	
1.4.5	Туслах малчдын амьжиргааг дэмжих, хөдөлмөрийн нөхцөлийг сайжруулах, мэргэжил эзэмшүүлэх, хүний эрхийн зөрчил, хүйсийн ялгаварлан гадуурхалт, хүчирхийллээс хамгаалах тусгай төлөвлөгөө гаргаж хэрэгжүүлнэ.	Төлөвлөгөө, хэрэгжилт	0	35	70	ХХААХҮЯ	
1.4.6	Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлал хөгжүүлэх чиглэлээр хөдөөгийн эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээ нэвтрүүлнэ.	Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан эмэгтэйчүүд	0	1000	3000	БОАЖЯ	
1.4.7	Улирлын шинжтэй ажил хөдөлмөр, гар аргаар ашигт малтмал олборлож байгаа иргэн, малчид болон нийгмийн эмзэг бүлгийн иргэдийг эрсдэлээс хамгаалах үйл ажиллагаанд ЖДШ хийж, төлөвлөгөө гарган хэрэгжүүлнэ.	ЖДШ, төлөвлөгөө ний хэрэгжилт	0	50	100	ХХААХҮЯ	
1.4.8	Хөдөөгийн охид, эмэгтэйчүүдийн аж байдлыг сайжруулах тухай НҮБ-ын тогтоолын хэрэгжилтийн үндэсний тайлан гаргаж, зөвлөмжийг хэрэгжүүлнэ.	Тайлан	0	2	4	ХХААХҮЯ, ГХЯ	

5

1.5.3	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийг хэрэгжүүлэх журмуудыг хуулийн үзэл баримтлал, агуулгын үүднээс шинжилж, боловсронгуй болгоно.	Үнэлгээнд суурилж, сайжруулсан журам, сургалтын хөтөлбөр батлагдсан эсэх	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	
1.5.4	Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх, хохирогчид тусламж, үйлчилгээ үзүүлэх салбар дундын хамтын ажиллагааг сайжруулсан Баянхонгор зэрэг аймгийн сайн туршлагыг судалж нэвтрүүлнэ.	Сайн туршлагыг нэвтрүүлсэн аймаг, сум, дүүрэг	0	50	85	ХЗДХЯ	
1.5.5	Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үзүүлэх цогц үйлчилгээний туршлага, арга зүйг орон нутгийн удирдлага, ТББ-уудад нэвтрүүлж, чадавхжуулна.	Чадавхжсан аймаг	3	6	12	ХЗДХЯ, ГХУСАЗЗ	
1.5.6	Гэр бүлийн хүчирхийллийн хохирогч болон өрх толгойлсон эмэгтэйчүүдэд зориулсан нийтийн сууцны сургууль цэцэрлэгт ойрхон барьж байгуулна.	Барьсан нийтийн сууц	0	1	5	Нийслэл, аймгийн Засаг дарга, ИТХ	
1.5.7	Малчдыг гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, илрүүлэлтийг сайжруулах, хохирогчийг хамгаалах үр дүнтэй тогтолцоо, арга зүйг бий болгоно.	Тогтолцоо бүрдсэн, аргачлал батлагдсан эсэх	Үгүй	Тийм	Тийм	ХНХЯ ХЗДХЯ	
1.5.8	Засаг захиргааны анхан шатны нэгжид ажиллаж байгаа Хамтарсан багийн болон Түр хамгаалах байрны үйл ажиллагааны зардлыг улсын болон орон нутгийн төсвөөс бүрэн санхүүжүүлэх хуулийн заалтыг хэрэгжүүлнэ.	Бүрэн санхүүжүүлэх эх хуулийн заалтын хэрэгжилт, орон нутгаар	-	70	100	ХЗДХЯ	
1.5.9	Хүүхэд, ялангуяа бэлгийн хүчирхийллийн хохирогч хүүхдийн хувийн нууцаа хамгаалуулах эрхийг бүрэн баталгаажуулсан эрх зүйн орчин бий болгоно.	Хуулийн зохицуулалт хийгдсэн эсэх	Үгүй	Тийм	Тийм	ХЗДХЯ	

6

1.5.10	Жендэрт суурилсан хүчирхийлэл, дарамтын үзүүлэх үйлчилгээний хүртээмж, цар сайжруулна.	Үйлчилгээ үзүүлэх журам, хэрэгжилт, санхүүжилт ийн өсөлт	25 -	28 50 100 Санхүүжилт нэмэгдсэн байна	-	ХЗДХЯ	
1.5.11	Жендэрт суурилсан хүчирхийллийн хохирогчид үйлчлэх Нэг цэгийн үйлчилгээний төвд шүүхийн шинжилгээний үйлчилгээг нэгтгэн үзүүлнэ.	Шүүхийн шинжилгээний үйлчилгээтэй НЦҮТ	0	100	-	ХЗДХЯ	
1.5.12	Нийслэл дэх Түр хамгаалах байрыг хүчирхийлэлд өртсөн хүүхэд, эмэгтэйчүүд болон эрэгтэйчүүд, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, ахмад настнуудад үйлчилгээ үзүүлэх чиглэлээр төрөлжүүлэн байгуулж, санхүүжилтийг хуулийн дагуу шийдвэрлэнэ.	Төрөлжсөн хамгаалах байр	0	6	10	ХЗДХЯ, ХНХЯ	
1.5.13	Жендэрт суурилсан хүчирхийллээс урьдчилан сэргийлэх нөлөөллийн ажлыг тогтмол зохион байгуулна.	Тогтмолжсон арга хэмжээ	1	5	16	Бүх яам	
2.2.13	"Ажиллагчдад жендэр, гэр бүлийн хариуцлагаас үл хамааран тэгш боломж олгох, тэгш хандах тухай" 156, "Цагийн ажлын тухай" 175, "Гэр орны ажлын тухай" 177, "Эхчүүдийн хамгааллын тухай" 183, "Хүчирхийлэл болон дарамтын тухай" 190 дүгээр конвенцуудад нэгдэн орно.	Нэгдэн орсон конвенц	0	4	5	ХНХЯ, ГХЯ	
3.2.10	И-Монгол цахим платформд жендэрийн үнэлгээ хийж, зөвлөмж гаргана.	Зөвлөмж хүргүүлсэн эсэх, зөвлөмжийн хэрэгжилт	Үгүй 0	Тийм -	- 100	ЦХХХЯ	
5.2.1	Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад чиглэсэн зохистой хэрэглээний дадлыг хэвшүүлэх сургалт, нөлөөллийн мэдлэгийн болон хэвлэл мэдээллийн бүтээгдэхүүнийг жендэрийн мэдрэмжтэй гаргаж түгээнэ.	Сургалт, нөлөөллийн бүтээгдэхүүн, төрлөөр	0	5	8	Соёлын яам	

5.2.5	Байгаль орчинд ээлтэй зохистой үйлдвэрлэлийн шинэ стандарт, зохистой хэрэглээний дадлыг нэвтрүүлэхэд аж ахуй эрхлэгчдийн мэргэжлийн холбоод, эмэгтэйчүүд, жендэрийн чиглэлээр ажилладаг ТББ, хэвлэл мэдээллийн хамтын ажиллагааг хөгжүүлнэ.	Арга хэмжээ	0	5	10	БОАЖЯ	
5.3.3	Уур амьсгалын өөрчлөлтийг бууруулах, дасан зохицоход хөдөөгийн эмэгтэйчүүд охидын хөдөлмөрийн бүтээмжийг дээшлүүлэх технологи дамжуулахад олон улсын түвшинд хамтарч ажиллана.	Нэвтрүүлсэн техник технологи	0	5	10	БОАЖЯ, ХХААХУ Я	
5.3.4	Байгаль орчинд ээлтэй аялал жуулчлалыг хөгжүүлэх чиглэлээр эмэгтэйчүүдийн чадавхыг бэхжүүлэх зөвлөх үйлчилгээг нэвтрүүлнэ.	Зөвлөх үйлчилгээний төрөл	1	4	6	БОАЖЯ	

-o-o-o-